



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/339

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

“Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/, 29.1.6 /г/, 29,2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах худалдааны төвүүдэд лангууны тохижилт хийхэд шаардлагатай 10200000 /Арван сая хоёр зуун мянган/ төгрөгийг Засаг даргын бусад зардлын жижиг худалдаа эрхлэгчдэд зориулсан стандартын худалдааны цэгүүдийг бий болгон ажлын байрыг нэмэгдүүлэх зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг ханган, дээрх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /н. Баяржаргал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар
сарын 19 өдрийн 4/339 дугаар захирамжийн
хавсралт

**ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭГЧИД БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БОРЛУУЛАХ
ЦЭГҮҮДИЙН ТОХИЖИЛТ ХИЙХ ТӨСӨВ**

Зорилго :Өрхийн үйлдвэрлэгчидийг дэмжих тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилтот үйл ажиллагааны хүрээнд Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй томоохон худалдааны төвүүдэд "Эрдэнэтэд үйлдвэрлэв " лангууг түрээсийн төлбөргүйгээр ажиллуулан удирдлага зохион байгуулалтаар ханган үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Д/д	Үйл ажиллагааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шилэн лангуу 1.2x1x50	20	ш	320,000	6,400,000
2	Ханын тавиур 1.2x2.4x0.4	10	ш	350,000	3,500,000
3	Хаяг хэвлэл /стикер/ 3.5 м2	5	ш	60,000	300,000
					10,200,000